БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр Дугаар А/718 Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, гарсан үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор Зиндаа.мн сайттай гэрээ байгуулах зардалд 2.500.000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгийн шаардагдах зардлыг баталсугай.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Тамгын газрын төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ